



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

“Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын
дүрэм”-ийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7, Засгийн газрын 2016 оны “Нийслэлийн Засаг даргын тамгын газар, захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” 8 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын даргад үүрэг болгосугай.

3. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д үүрэг болгосугай.

САЙД



Н.НОМТОЙБАЯР

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар (цаашид “газар” гэх) нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх үйл ажиллагааг дүүрэг, хороодын онцлог, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тэгш, хүртээмжтэй зохион байгуулах үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг байна.

1.2. Газар нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаал болон энэ дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газрын үйл ажиллагаа нь хууль дээдлэх зарчимд үндэслэсэн, олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай байх, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, түншлэлийг бэхжүүлэхэд чиглэсэн байна.

1.4. Газар нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэж, төрийн санд бүртгэлийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн харилцах данстай байна.

1.5. Газрын үндсэн чиг үүрэг, үйлчилгээний зарчим, удирдлага, зохион байгуулалт болон бусад харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

Хоёр. Газрын үйл ажиллагааны зарчим, бүрэн эрх, үндсэн чиг үүрэг

2.1. Газар нь төрийн байгууллагын нийтлэг үнэт зүйл, зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үйлчилгээний нэр төрөл, тоо чанар, арга хэлбэрийг боловсронгуй болгох, үйлчилгээ үзүүлэх хэлбэр, арга зүйг сайжруулах үндсэн дээр иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээг үр ашигтай, шуурхай хүргэх үүргийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хүлээнэ.

2.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлж, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Төсвийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана.

2.3. Газрын дэргэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэг бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй байж болно.

2.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.4.1. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийт ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон болон сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээлэл цуглуулах, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

2.4.2. ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах;

2.4.3. Хууль тогтоомж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөөг тооцох, санал боловсруулах;

2.4.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7-д заасан төлбөрийг төвлөрүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

2.4.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан санал, дүгнэлт гаргах, хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих;

2.4.6. хөдөлмөрийн хувийн бирж болон мэргэжлийн сургалтын байгууллагуудын бүртгэл, судалгаа гаргах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

2.4.7. холбогдох хууль тогтоомжийг байгууллага, иргэнд сурталчлах;

2.4.8. нийслэлийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;

2.4.9. хөдөлмөрийн асуудлаарх захиргааны болон үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэж зохих журмын дагуу тайлагнах;

2.4.10. ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх;

2.4.11. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.4.12. Бичил бизнес эрхлэгчийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;

2.4.13. Нийслэлийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх;

2.4.14. Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилд зарласан зорилттой уялдуулан үйл ажиллагаа явуулах;

2.4.15. Газар нь өөрийн цахим хуудастай байх ба Нийслэлийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулна.

2.5. Нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ тайлан, бүртгэл судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулна;

2.6. Нийслэлийн нутаг дэвсгэрийн онцлог, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр санаачлан боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;

2.7. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гурав. Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц, санхүүжилт

3.1. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч тогтооно.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д заасны дагуу Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

3.3. Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлж, газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

3.4. Газрын дарга нь ажлаа агентлагийн даргын өмнө шууд хариуцан тайлагнах бөгөөд төсвийн шууд захирагчийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцлага хүлээнэ.

3.5. Сайдын зөвшөөрснөөр газрын дарга нь агентлагийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Агентлагийн

даргаас газрын даргын үр дүнгийн гэрээг дүгнэж, үнэлгээний дагуу авах арга хэмжээний саналыг сайдад уламжилна.

3.6. Газрын дарга байгууллагын жилийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг үнэлж дүгнэх, албан хаагчдыг мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө захиран зарцуулах, бүтцийн нэгжийн дарга, мэргэжилтэн, ажилтанг томилох, чөлөөлөх, ажлын үр дүнг үндэслэн шагнаж, урамшуулах, хариуцлага тооцох болон хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.7. Газрын дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн тушаал, шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангуулна.

3.8. Газар нь “дотоод журам”-тай байх бөгөөд албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж, биелэлтэд нь Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга хяналт тавьж, газрын даргад танилцуулан ажиллана.

3.9. Газрын ажилтан албан хаагчдын эрх, үүргийг хууль тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

3.10. Газар нь Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Сургалт судалгааны хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэстэй байна.

3.11. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх удирдлагын зөвлөлийг байгуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

3.12. Газар нь дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийг удирдлага арга зүйгээр хангаж, үйл ажиллагааны тайлан мэдээг авч нэгтгэнэ.

3.13. Газрын үйл ажиллагааны зардлыг улсын төсөв, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус тус санхүүжүүлнэ.

3.14. Газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тэнцвэрийг хангаж, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх бодлого баримтлан ажиллана.

Дөрөв. Бусад

4.1. Газар нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, нийслэлийн Засаг даргыг хууль тогтоомж, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мэдээллээр цаг тухайд нь шуурхай хангаж ажиллана.

4.2. Салбарын хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулна.

4.3. Газрыг салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар агентлаг хангаж ажиллана.

4.4. Салбарын хэмжээнд агентлаг болон харьяа газар, байгууллага дотоод сүлжээг албан хэрэгцээндээ ашиглаж болно.

4.5. Дүрэмд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.